



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 3/3

Номгон

**Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх шаардлагатай дараах ажлуудыг удирдлагаар хангаж, хэрэгжилтийг зохион байгуулж, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

1.1. Малчдад мал, мах бэлтгэлээр 2020 онд үүссэн өр үүссэн байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй аймгийн удирдлагуулын түвшинд холбоо тогтоож, өрийг түргэн шуурхай хугацаанд барагдуулах

1.2. Малын эрүүл мэнд, генетик нөөц, удмын санг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах, аймаг, сум бүрт малчин өрхийн мал сүргийн чанарыг бодитой сайжруулахуйц төрийн болон аймаг орон нутгийн бодлогоор хамгаалагдсан цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгчийг бүрдүүлэн өсгөж үржүүлэх, малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүдийг дэмжих хөрөнгө санхүүг богино хугацаанд нэн даруй шийдвэрлэх

1.3 Бэлчээрийн доройтол, цөлжилт бууруулах, бэлчээрийг сэргээх, цөөн тооны чанартай малтай үлдэх, мал малын гаралтай түүхий эдийг үр дүнтэй эргэлтэд оруулах түүхий эд борлуулалтын оновчтой бирж, сүлжээг нэвтрүүлэх, хоршоодыг бодлого арга зүйгээр дэмжих

1.4. Малын үзлэг ангилалтыг чанартай тогтвортой гүйцэтгэж, сайн үүлдэр омгийнхоо малын удмын санг хамгаалах, бэхжүүлэх, байгаль цаг уурын эрсдлийг тэсвэрлэх чадвар өндөртэй малыг өсгөх, нэгжээс авах ашиг шимийг богино хугацаанд эрс нэмэгдүүлэх бодлого барьж, Залаажинст-Идрэнгийн цагаан үүлдэр, Бөмбөгөрийн улаан, Баянбулагийн омгийг бусад сумдад сайжруулагчаар ашиглах, ноолуурын мкм хэмжигч багаж Ланометрийг авч ноолуур судлалаа аймагтаа хийдэг

болох

1.5. Малчдад өрхийн хэмжээний хүнсний ногоо, малын тэжээлийн ургамлын тариалалт эрхлэхийг дэмжих, талбайн хамгаалалт чанартай үрийн тогтвортой нийлүүлэлтээр хангах асуудлыг анхаарч бодлого төлөвлөлтөд тусгаж, хэрэгжүүлэх

1.6. Аймгийн мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулж, хөрөнгийн асуудлыг 2021 оны төсвийн тодотгол бусад эх үүсвэрээс шийдвэрлэн ажиллах

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

